



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/431

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2, 28 дугаар зүйлийн 5, 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 51 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Буянт багт байрлах “Хан-Алтайн дуулал” цогцолбор барилга, Цамбагарав багт байрлах Амарсанаагийн цэцэрлэгт хүрээлэн доторх гэр зэрэг үндсэн хөрөнгүүдэд засвар үйлчилгээ хийж цаашид 5 хүртэлх жилийн хугацаанд ашиглах төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын

хэсгийн ахлагч: Л.Энхбаяр (Засаг даргын орлогч)

Ч.Эрдэнэбат (Засаг даргын Тамгын газрын хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ц.Пүрэвсүрэн (Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Х.Болормаа (Засаг даргын Тамгын газрын нярав)

Ц.Даваасамбуу (Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)

Б.Ууганчимэг (Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын төсөв хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн)

Нарийн

бичгийн дарга:

Г.Жавзанхорлоо (Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

8400001 1295

Zah A/431 Doc

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хуулийн хүрээнд зохион байгуулж, тайлагнан ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Засаг даргын орлогч (Л.Энхбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.АМАРСАНАА